

Аудитын код: САГ-2018/08/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: hkosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа
Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын хураангуй тайлан	2
2	Аудитын гэрчилгээ	4
3	Аудитын тайлан.....	6
3.1	Оршил.....	6
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
3.5	Дотоод хяналт.....	8
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	9
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	9
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	9
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	10
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	10
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	10
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3.16	Үр өгөөжийн тооцоолол	11
4	Менежментийн захидал.....	12
4.1	Санхүүгийн тайлагналын талаар	13
5	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	14
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
6	Зөрчлийн жагсаалт.....	20
6.1	Албан шаардлага.....	21



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГА Ж.БЯМБАДОРЖ
ТАНАА

2018.04.25 № 1021
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG10.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

070442

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Хүний эрхийн Үндэсний Комиссын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 05-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг, аудитор П.Амарсанаа хариуцаж хэрэгжүүлэв.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Хүний эрхийн Үндэсний Комиссын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 4/191 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах;
- Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах;
- Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх;
- Түүнчлэн Комиссын гишүүн Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцах, холбогдсон хууль, тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий албан тушаалтан, байгууллагад уламжлах.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Хүснэгт 1. Хүний эрхийн Үндэсний комиссын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Д/д	Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр хүрэх үр дүн, биелэлт			
	Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр	2017 оны зорилтот түвшин	Биелэлт	Хувь
1	Хяналт, шалгалт судалгаа, дүн шинжилгээ	Хяналт шалгалт 10, мониторинг 5, хууль тогтоомж дүн шинжилгээ санал гаргах 20	Хяналт шалгалт 99, Судалгаа шинжилгээ 134, шинжилгээ санал гаргах 6	830%
2	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн асуудлаарх өргөдөл, гомдол шийдвэрлэх	700	502	72%
3	Иргэдийн зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх асуудлаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулах асуудлаар зөвлөмж хүргүүлэх	Төлөөлөн нэхэмжлэл 4, шаардлага 15, зөвлөмж 15	Төлөөлөн нэхэмжлэл 2, Зөвлөмж 22	100%
4	Хүний эрхийн боловсрол дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа	2500	23,765	792%

Эх сурвалж: www.mn-nhrc.org

Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.



3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хүний эрхийн Үндэсний Комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016, 2017 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах асуудлыг дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал.

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн санхүүгийн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.


3.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнг 5 үзүүлэлтээр баталгаажуулжээ.



Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 805.6 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 5.5-д дэлгэрэнгүй харуулав. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 762.9 сая төгрөг буюу 94.7 хувьтай байна.

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар зардал хэтрээгүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (хагас, бүтэн жилээр, сар улирал бүр)
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
- Санхүүгийн тайлан (хагас, бүтэн жилээр)
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил, үйлчилгээний гүйлгээ (тухай бүр)
- Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Хүний эрхийн Үндэсний Комисстой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах алдаа, зөрчил илэрснийг доорх байдлаар шийдвэрлэсэн болно.

Үндсэн хөрөнгөнд санхүүгийн Acolous програм бүртгэлтэй байгаа боловч нягтлан бодох бүртгэлээ програмаар бэлтгээгүй байгаа нь бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах, байгууллагын удирдлагыг санхүүгийн мэдээллээр цаг тухайд нь хурдан шуурхай хангах боломж дутмаг, санхүүгийн тайлан архивлагдахгүй өгөгдлийн сангүй болох зэрэг эрсдэлтэй байгаа ба өмнөх аудитаар уг асуудлаар зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлээ санхүүгийн програмд бэлтгэж байх албан шаардлага өгөв.



Үндсэн хөрөнгө, бараа материалын 2017 оны жилийн эцсийн тайлан нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулаагүй, харилцах дансны үлдэгдлийн баталгаа ирүүлээгүй, харилцах кассын баримтыг архивын нэгж болгоогүй, нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт сул байгаа зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "19.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 13.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 171.5 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.6-д "бүх зардал;" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

Санхүүгийн тайланд урьдчилгаа дансыг 1.7 сая төгрөгөөр илүү, бараа материалыг /ном товхимол/ 3.5 сая төгрөгөөр дутуу тайлагнаж тайлангийн үеийн үр дүнг 1.8 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байгаа нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4.20-д "Төсөвт байгууллага бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа байнгын системийн аргыг ашиглана." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд анхаарал татахуйц бусад асуудал гараагүй болно.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн үйл ажиллагааг програмын тусламжтай бэлтгэсэн, үндсэн хөрөнгө бараа материалын тайланд тавих дотоод хяналтыг үзнэ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 194.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.


Алдаа, зөрчил илрүүлж 194.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 1 зөвлөмж, нягтлан бодох бүртгэлийг цахимжуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй ба нягтлан бодох бүртгэлийн тооцооллоо эрсдэлээс ур ьдчилан сэргийлж цахимжуулах арга хэмжээ авах гэсэн зөвлөмжийн дагуу Acolous програмыг ашиглахаар эрхийг нь сэргээсэн боловч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандард 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр



санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов. Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 1,025.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 20.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.14-т тусгасан бөгөөд материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Үр өгөөжийн тооцоолол

Хүний эрхийн Үндэсний комиссын даргын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үр өгөөжтэй асуудал гараагүй байна.



4 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Санхүүгийн тайлагналын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан нягтлан бодогчийн гарын үсгээр баталгаажуулаагүй, харилцах дансны үлдэгдлийн баталгаа ирүүлээгүй, харилцах кассын баримтыг архивын нэгж болгоогүй нь бүртгэлээр тавих дотоод хяналт сул байгаа зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д " Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно " гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй. байна.

Эрсдэлүүд:

Хөрөнгө алга болох, шамшигдах

ҮАГ-ын зөвлөмж:

Үндсэн хөрөнгө, бараа материалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зөрчлийг давтан гаргахгүй байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дугаар сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	/мян.төг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63,216.9	49,277.4
АВЛАГА	18,538.0	16,811.0
УРЬДЧИЛГАА	22,880.5	8,614.5
БАРАА МАТЕРИАЛ	21,798.4	23,852.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	147,906.8	
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	147,906.8	117,389.9
Биет хөрөнгө	142,506.8	115,229.9
Биет бус хөрөнгө	5,400.0	2,160.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	211,123.7	166,667.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,808.5	
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,808.5	
Өглөг	4,808.5	
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	206,315.2	166,667.3
Засгийн газрын хувь оролцоо	206,315.2	166,667.3
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,347.9	108,348.0
Хуримтлагдсан үр дүн	89,067.1	49,419.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	8,900.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	211,123.7	166,667.3



5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	901,709.3	984,397.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	901,709.3	984,397.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	879,705.5	1,024,045.7
УРСГАЛ ЗАРДАЛ	879,705.5	1,024,045.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	863,088.2	936,353.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,546.5	506,822.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,524.1	55,830.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,840.0	48,333.6
Хангамж, бараа материалын зардал	54,420.0	60,928.7
Томилолт, зочны зардал	65,520.7	47,071.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,350.6	25,573.0
Бараа үйлчилгээний бусад зардал	101,886.3	191,793.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,617.3	87,692.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	22,003.7	(39,647.9)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	22,003.7	(39,647.9)



5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,320.0	0.0	164,320.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,320.0	0.0	164,320.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	19,991.4	0.0	19,991.4
Тайлант үеийн үр дүн	22,003.7	0.0	22,003.7
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,315.2	0.0	206,315.2
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	206,315.2	0.0	206,315.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,315.2	0.0	206,315.2
Тайлант үеийн үр дүн	(39,647.9)	0.0	(39,647.9)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,667.3	0.0	166,667.3



5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	903,360.8	1,002,935.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	903,360.8	1,002,935.8
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	903,305.8	1,002,810.8
УРСГАЛ ЗАРДАЛ	903,305.8	1,002,810.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,150.5	898,338.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,542.6	507,826.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,425.3	55,861.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,840.0	48,333.6
Хангамж, бараа материалын зардал	50,848.8	65,293.8
Томилолт, зочны зардал	65,520.7	47,071.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,350.6	25,573.0
Бараа үйлчилгээний бусад зардал	111,622.5	148,378.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,155.3	104,472.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	55.0	125.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	55.0	125.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55.0	125.0
Дотоод эх үүсвэрээр	55.0	125.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(55.0)	(125.0)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	(0.45)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.45	0.45
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.45	0.0



5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	805,625.2	762,940.4	42,684.8	94.7
УРСГАЛ ЗАРДАЛ	805,625.2	762,940.4	42,684.8	94.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,121.8	717,932.5	6,189.3	99.1
Ажил олгогчоос НДаатгалд төлөх шимтгэл	55,861.0	55,861.0	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,333.6	48,333.6	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	63,976.9	63,976.9	-	100.0
Томилолт, зочны зардал	8,748.6	8,748.6	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,761.4	25,573.0	6,188.4	80.5
Бараа үйлчилгээний бусад зардал	7,613.1	7,613.1	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,095.2	19,095.2	-	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	19,095.2	19,095.2	-	100.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	62,408.2	25,912.7	36,495.5	41.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	805,625.2	762,940.4	42,684.8	94.7
Улсын төсвөөс санхүүжих	805,625.2	762,940.4	42,684.8	94.7
Улсын төсвөөс санхүүжих	805,625.2	762,940.4	42,684.8	94.7
Урсгал санхүүжилт	805,625.2	762,940.4	42,684.8	94.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.45-	0.45	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.45	0-	-	



5.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,074.5	180,530.6
УРСГАЛ ЗАРДАЛ	170,074.5	180,530.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,536.5	180,530.6
Тээвэр шатахуун		1,441.9
Томилолт, зочны зардал	53,045.5	38,322.9
Бараа үйлчилгээний бусад зардал	98,491.0	140,765.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,538.0	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,074.5	180,530.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	170,074.5	180,530.6
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	170,074.5	180,530.60

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**